



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/393

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Соёлын тухай хуулийн 27 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны 07 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад ард Улсын Ганьсу мужийн Ланжоугийн хөрөнгө оруулалт, худалдааны 31 дэх удаагийн үзэсгэлэн яармагт аймгийн Засаг даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалт татах, харилцан ашигтай түншлэлийг хөгжүүлэх зорилгоор оролцох тус арга хэмжээнд зарцуулагдах унаа шатахууны зардлыг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээнд зарцуулагдах 3,408,200 (гурван сая дөрвөн зуун найман мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дүгээр сарын 01 ний өдрийн 395
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардал	Нийт үнэ
1	Шатахуун / 1268 км/	1268км*3000= 3,408,000
Нийт дүн		3,408,200